МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 11 өдөр Дугаар А/517 Улаанбаатар хот

КОВИД-19 халдварын үеийн бэлэн байдлыг хангаж, эмнэлэг нээж ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.23 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. КОВИД-19 халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II”-ийн үйл ажиллагааг эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг нэгдүгээр; ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, дэд сайд /Ш.Анхмаа/-д даалгасугай.

САЙД Т.МӨНХСАЙХАН

2020-A-tushaal

141202027

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11..-ний өдрийн А/... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт 517

# КОВИД-19 ХАЛДВАРЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ, "ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. **Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Эрүүл мэндийн дэд сайд |
| Гишүүд: | Төрийн захиргааны удирдлагын газрын дарга |
| | Эмнэлгийн тусламжийн газрын дарга |
| | Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга |
| | Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| | Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга |
| | Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга |
| | Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтсийн дарга |
| | Эмнэлгийн тусламжийн газрын Лавлагаа шатлалын тусламж хариуцсан ахлах шинжээч |
| | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга |
| | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал |
| | "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II"-ийн ерөнхий захирал |
| | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал |
| | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал |
| | Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга |
| | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэлийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр) |
| Нарийн бичгийн дарга: | Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга |

Хоёр. **Ажиллах удирдамж**

**Зорилго:**

"Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II" лавлагаа шатлалын тусламжийг эхлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

**Үйл ажиллагааны чиглэл:**

1. "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II"-ийн дүрэм, бүтэц, орон тоог боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах,
2. Төвийг улсын бүртгэлд бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ болон төвийн барилга, барилгын доорх газар эзэмших гэрчилгээ авах, тамга, тэмдэг захиалан хийлгэх, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах,
3. Төвийн үйл ажиллагаанд шаардагдах эдийн засгийн өртөг, зардал, төсвийн тооцооллыг хийж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны батлагдсан төсвийн багцад багтаан шийдвэрлэх, дараа жилийн улсын төсвийн төсөлд тусгах,
4. Хувийн салбар, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр зэрэг санхүүжилтийн бусад эх үүсвэрээс хөрөнгө татах асуудлыг шийдвэрлэх,
5. Эх, нярай, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ эрхлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрлийг олгож, магадлан итгэмжлэлд хамруулах, Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулах,
6. Төвийг нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдсан 300 ор бүхий төрөх эмнэлгийн байранд байршуулан зохион байгуулалтын дараах арга хэмжээ авах:
   - Өнөөдрийг хүртэл бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгүүлэх,
   - ТЭЗҮ-д тусгагдсан техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, түргэн тусламжийн машин, тавилга, эд хогшил, хөрөнгөөр хангах асуудлыг салбарын хөрөнгө оруулалтаас шийдвэрлэх,
   - Шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг салбарын хүний нөөц болон эрүүл мэндийн байгууллагуудаас гэрээгээр болон сэлгүүлэн ажиллуулах, дагалдуулан сургах асуудлыг шийдвэрлэх,
   - Хөрөнгө, хүний нөөцийг нүүлгэн шилжүүлэх, байршуулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах,
   - Төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад эрүүл мэндийн байгууллагуудыг татан оролцуулах.

**Үр дүн:**

"Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II"-ийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэх бэлтгэл хангагдана.

oOo

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11..-ний өдрийн А/517.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## КОВИД-19 ХАЛДВАРЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ, ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Огноо | Хариуцах эзэн | Хамтрах байгууллага | Үр дүн |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бэлэн болгох** | | | | | |
| 1. | "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II"-ийн дүрэм, бүтэц, орон тооны төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ТЗУГ- ХХ | ЭНЭҮТ-II | Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна |
| 2. | Төвийг улсын бүртгэлд бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ, төвийн барилга, барилгын доорх газар эзэмших гэрчилгээ авах, тамга, тэмдэг захиалан хийлгэх, хэвлэмэл хуудас хэвлүүлэх, байгууллагын данс нээлгэх | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ТЗУГ- ХХ ЭЗСХОГ | ЭНЭҮТ-II | Улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрчилгээ, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас бэлэн болсон байна.<br>Төрийн сангийн болон холбогдох бусад данс нээгдсэн байна. |
| 3. | Төвийн үйл ажиллагааны эдийн засаг, өртөг, зардал, төсвийн тооцооллыг гаргаж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны батлагдсан төсвийн багцад багтаан шийдвэрлэх, 2021 оны улсын төсөвт тусгах | 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор | ЭЗСХОГ | ЭНЭҮТ-II | Санхүүгийн тооцоолол хийсэн байна.<br>2020 оны 11-12 дугаар сарын санхүүжилт бүрэн шийдэгдсэн байна.<br>2021 оны улсын төсөвт тусгасан байна. |
| 4. | Эх, нярай, хүүхэд, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох | 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор | ТЗУГ | ЭНЭҮТ-II | Тусгай зөвшөөрөл олгогдсон байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | Эх, нярай, хүүхэд эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ эрхлэх магадлан итгэмжлэлд хамруулах | 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор | ТЗУГ, ЭТГ ЭМХТ | ЭНЭҮТ-II | Магадлан итгэмжлэл олгогдсон байна. |
| 6. | Эх, нярай, хүүхэд, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ эрхлэх Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулах, | 2020 оны 11 дүгээр сарын 30-ны дотор | БТГ-ЭМДХ ЭМДЕГ | ЭНЭҮТ-II | ЭМДаатгалын гэрээ байгуулсан байна. |
| **Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай хангалтыг хийх** | | | | | |
| 7. | Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай, ТЭЗҮ-д тусгагдсан техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, тавилга, цахим тоног төхөөрөмж, хэрэгсэл, эд хогшлын жагсаалтыг гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хангах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ЭТГ<br>ЭҮТГ | ЭНЭҮТ-II | Хөрөнгө оруулалтууд шийдвэрлэгдэж, хангалт хийгдсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна. |
| 8. | Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг гэрээгээр худалдан авч, хангах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ЭҮТГ- ЭЭХХ<br>НЭМГ | ЭНЭҮТ-II | Хангалтууд хийгдсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна. |
| 9. | Эмнэлгийн байрыг бүрэн цэвэрлэж, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын байрны дүгнэлт гаргуулах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ТЗУГ-ХХ | ЭНЭҮТ-II, Лавлагаа төвүүд, НЭМГ, Цэвэрлэгээний ААН | Эмнэлгийн барилгыг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд бүрэн бэлтгэсэн байна.<br>Ажлын байрны дүгнэлт гарсан байна. |
| 10. | Хүчилтөрөгчийн хангамжийн бэлтгэх, хүчилтөрөгчийн үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлынг шуурхай зохион байгуулах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ЭТГ<br>ЭҮТГ | ЭНЭҮТ-II | Хөрөнгө оруулалтууд шийдвэрлэгдэж, хангалт хийгдсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна. |
| 11. | Эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангаж, суурилуулж, ажиллуулах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ЭТГ | ЭНЭҮТ-II | Хөрөнгө оруулалтууд шийдвэрлэгдэж, хангалт хийгдсэн байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна. |
| 12. | Эрчимт эмчилгээний тасгийн бүрэн тоноглож, тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангах | 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ЭТГ<br>ЭТҮГ | ЭНЭҮТ-II | Хөрөнгө оруулалтууд шийдвэрлэгдэж, хангалт хийгдсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын тушаал гарсан байна. |
| 13. | Дулаан, цахилгаан, ус суваг, холбоо, хог хаягдал зэрэг тусламж үйлчилгээг хэвийн явуулахад шаардлагатай гэрээнүүдийг шуурхай байгуулах | 2020 оны 11 дүгээр сарын 10-ны дотор | ТЗУГ | ЭНЭҮТ-II | Холбогдох гэрээнүүдийг байгуулсан байна. |
| 14. | Одоогоор бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгүүлэх | 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ТЗУГ-ХХ | ЭНЭҮТ-II | Төрийн өмчид бүртгэгдэх өмч хөрөнгийн жагсаалт гарч, төрийн өмчид бүртгэгдсэн байна. |
| 15. | Хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх, байршуулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>СЭЗХ<br>ХОХ<br>ТЗУГ | ЭНЭҮТ-II | Хөрөнгө шилжүүлэхэд шаардагдах зардал, унаа шатахууныг шийдвэрлэсэн байна.<br>Хөрөнгө бүрэн шилжсэн байна. |
| 16. | Тусгаарлах өрөөний улаан, шар, ногоон бүс болон халдвараас сэргийлэх урсгалыг тогтоож, камержуулах | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ХОХ<br>ХӨСҮТ<br>ЗӨСҮТ | ЭНЭҮТ-II | Бүсийг тогтоосон байна.<br>Камер суурилагдсан байна. |
| 17. | Тасаг нэгжүүдийг цахим сүлжээнд холбох, мэдээллийн сан, крограммуудыг суулган, үйл ажиллагааг жигдрүүлэх | 2020 оны 11 дүгээр сарын 12-ны дотор | ЭЗСХОГ<br>ЭММТХ<br>ЭМДХ | ЭНЭҮТ-II<br>ЭМХТ<br>ЭМДЕГ | Цахим сүлжээтэй болсон байна. |
| **Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах** | | | | | |
| 18. | Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын судалгааг холбогдох стандартуудад нийцүүлэн мэргэжил бүрээр гаргах | 2020 оны 11 дүгээр сарын 11 | ТЗУГ, ЭТГ, ЭМХТ | ЭНЭҮТ-II<br>Лавлагаа төвүүд | Хүний нөөцийн хэрэгцээ мэргэжил бүрээр гарсан байна. |
| 19. | Нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг салбарын хүний нөөц болон эрүүл мэндийн байгууллагуудаас | 2020 оны 11 дүгээр сарын 11-нээс эхлэн өдөр бүр | ТЗУГ, ЭМХТ | ЭНЭҮТ-II<br>Лавлагаа төвүүд<br>НЭМГ | Гэрээ байгуулагдсан байна.<br>Сургалтууд хийгдэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | гэрээгээр болон сэлгүүлэн ажиллуулах, дагалдуулан сургах сургалтын хөтөлбөр боловсруулан, бэлтгэх ажлыг зохион байгуулах | | | | |
| 20. | Мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс судалж, ажилд томилох | 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор | ТЗУГ, ЭМХТ | ЭНЭҮТ-II Лавлагаа төвүүд, АШУҮИС | Эмч мэргэжилтнүүдийг судалж ажилд томилон гэрээ байгуулах |

ooOoo